

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЭУГ-2025/21-ШТА-НА

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор М.Номиндарь

Утас: 70533552 Цахим хаяг: Nomindarim@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилго	3
Аудитын хамарсан хүрээ	3
Аудитын арга зүй.....	3
Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд.....	3
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн	4
Ерөнхий мэдээлэл.....	4
БҮЛЭГ-1 ХУУЛИЙН 15 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	5
А.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон албан хаагчдын цалингийн жишгийг батлаагүй байна.	5
А.2. Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгал зүйл авах, контент бэлтгэх зөрчил жил бүр давтагдсаар байна.	7
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	8
Б.1. Хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зохион байгуулах журмыг зөрчсөн зөрчил буурч байна.	8
Б.2. Цахим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй зөрчил өссөн байна.	9
БҮЛЭГ 3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН ЗӨРЧЛИЙН ТОО БУУРСАН БАЙНА.....	10
В.1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажилласан байна.	10
В.3 Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	11
ДҮГНЭЛТ	0



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ЗГТ	Засгийн газрын тогтоол
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Зөрчсөн хуулийн зүйлээр	4
Хүснэгт 2	Хуулийн 8.1 дэх заалтыг зөрчсөн байгуулга, зөрчлийн тоо, төсөв	6
Хүснэгт 3	Хуулийн 13 дугаар зүйлд заасан зөрчил заалтаар	8
Хүснэгт 4	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө	9
Хүснэгт 5	Хуулийн 14 дүгээр зүйлийн зөрчлийг заалтаар	9
График 1	Хуулийн 12 дугаар зүйлийг зөрчсөн байгуулга, зөрчлийн тоо, төсөв	6
График 2	Хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн байгуулга, зөрчлийн тоо, төсөв	7
График 3	Цахилгаан, дулааны зардал өсөж, цэвэр усны хэрэглээний зардлын үзүүлэлт	8



Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.10-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх,
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх
- төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022-2024 оны санхүүгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан, Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд, зарим орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС-100, 400, 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-4:2020, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах судалгааг хийж, нотлох баримтыг цуглуулж түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэсэн.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль



Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, аудитор М.Номиндарь, Т.Хишигбат нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

Ерөнхий мэдээлэл

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээс хойш Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар тус хуулийн 19 дүгээр зүйлд заасны хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэн санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд хууль зөрчсөн 1,049.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 30.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 897.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 122.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2024 онд хууль зөрчсөн 1,304.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 34.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 732.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 538.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Зөрчлийг хуулийн заалтаар ангилан харуулбал:

Хүснэгт 1. Зөрчсөн хуулийн зүйлээр:

№	Хуулийн заалтаар	Зөрчлийн тоо			нийт
		2022 он	2023 он	2024	
1	4 дүгээр зүйл. Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим	1	0	0	1
2	5 дугаар зүйл.Тэргүүн дэд, дэд, орлогч дарга	1	0	1	2
3	6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл	7	2	0	9
4	8 дугаар зүйл.Дүрэмт хувцас	6	4	7	17
5	12 дугаар зүйл.Бусад хангамж	14	2	6	22
6	13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	5	8	2	15
7	14 дүгээр зүйл.Цахим худалдан авалт	5	13	15	33
8	15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ	41	35	34	110
9	20 дугаар зүйл.Тайлагналт, ил тод байдал	2	0	0	2
Нийт		82	72	76	230

Дээрх судалгаанаас харахад хууль зөрчсөн зөрчил 2022 онтой харьцуулахад 7 хувиар буурсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйл буюу Цахим худалдан авалттай холбоотой зөрчил өссөн, бусад зөрчлийн тоо буурсан байна.

Нийт зөрчлийг хуулийн заалтаар харьцуулан харахад хуулийн 15 дугаар зүйл буюу хэмнэлтийн бусад арга хэмжээний зөрчил нийт зөрчлийн 47.8 хувийг эзэлж байна.



БҮЛЭГ-1 ХУУЛИЙН 15 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

А.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон албан хаагчдын цалингийн жишгийг батлаагүй байна.

1.1. Өмнөговь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагуудаас тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Цагдаагийн газар, Онцгой байдлын газар зэрэг байгууллагаас бусад байгууллага тэргүүн дэд, дэд, орлогч дарга томилж ажиллуулаагүй байна.

1.2. “Говь гурван сайхан орон сууц” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоонд дэд даргын албан тушаалыг баталж 1 албан хаагч томилсон зөрчлийг 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж арга хэмжээ авч хэрэгжүүлснээр цалин, урамшуулал болон холбогдох бусад зардлыг 1.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

1.3. Харин Даланзадгад сумын Засаг даргын А/06 дугаар захирамжаар Даланзадгад сумын захирагчийн ажлын албаны орлогч дарга гэсэн албан тушаалыг батлуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

1.4. Өмнөговь аймагт аймгийн Засаг даргын орлогч 1, сумын засаг даргын орлогч 15 байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.2 дахь хэсэгт заасан нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглосон заалттай нийцэж байна.

1.5. Аудитад хамрагдагч нийт 195 байгууллага холбогдох заалтыг хэрэгжүүлж зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалын орон тоо батлуулаагүй байна.

1.6. Харин “Өмнөговь корпорац” зөвлөх чиг үүрэг бүхий 8 зөвлөх инженерийг бүтэц орон тоондоо батлуулж, хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан зөрчил илэрсэн. Тус зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

1.7. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, аймаг, сумдын Засаг дарга болон зарим сумын багийн дарга нар нийт 47 албан тушаалын суудлын авто машин ашиглаж байна. Үүнээс: Аймаг, сумын ИТХ-н дарга нийт 5, аймаг, сумын Засаг дарга 16, багийн дарга 24 албан тушаалын авто машинтай байна.

1.8. Аудитад хамрагдагч байгууллагаас 109 байгууллагад бүртгэлтэй нийт 682 авто тээврийн хэрэгсэл байна. Эдгээр тээврийн хэрэгсэл нь төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хийсэн байдал 89.4 хувьтай байна.

1.9. Бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах өнгө бүхий улсын дугааргүй 17 авто машиныг улсын дугаарыг сольж зөрчил арилгах албан шаардлагыг 9 байгууллагад хүргүүллээ.

1.10. Хуулийн 8.1¹ дэх хэсэгт зөвшөөрснөөс бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон заалт бүрэн хэрэгжихгүй байна.

¹ ТХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

1.11. Хориглосон заалтыг зөрчсөн зөрчил 2022 онд 6, 2023 онд 4, 2024 онд 4 гаргаж нийт 22.7 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 2: Хуулийн 8.1 дэх заалтыг зөрчсөн байгууллага, зөрчлийн тоо, төсөв

(сая.төгрөг)

№	Зөрчил гаргасан байгууллага	2022 он		2023 он		2024 он	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гурвантэс сумын Засаг дарга	-	-	1	0.7	-	-
2	Ноён сумын Засаг дарга	1	0.9	-	-	-	-
3	Номгон сумын Засаг дарга	1	0.8	-	-	-	-
4	Ханбогд сумын засаг дарга	-	-	-	-	1	0.4
5	Хүрмэн сумын Засаг дарга	-	-	1	3.5	-	-
6	Цогт-Овоо сумын Засаг дарга	-	-	-	-	1	0.8
7	Булган сумын ЗДТГ	1	1.8	-	-	1	2.6
8	Даланзадгад сумын ЗДТГ	-	-	1	2.7	-	-
9	Сэврэй сумын ЗДТГ	1	0.6	-	-	-	-
10	Цогт-Овоо сумын ЗДТГ	1	3.5	-	-	-	-
19	Тос тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ	-	-	1	0.5	-	-
20	Цогтцэций сумын "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ	-	-	-	-	1	4.6
21	Баян-Овоо сумын "Долоошар заг" ОНӨААТҮГ	1	0.3	0	-	0	-
НИЙТ		6	7.9	4	6.4	4	8.4

1.12. Хуульд заасан албан томилолтын зардлыг хязгаарласан зөрчил 2022 оноос хойш давтан гараагүй байна.

1.13. Хуулийн 10.1² дэх хэсэгт заасан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоогоогүй байна.

1.14. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 14/19 дүгээр тогтоолоор “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг баталж тус журмын дагуу гүйцэтгэх захирлын цалинг аймгийн Засаг даргатай байгуулах гэрээнд тусгаж байна.

1.15. Цаашид хуулийг хэрэгжүүлж орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон албан хаагчдын цалингийн жишгийг баталж ажиллах талаар аймгийн ИТХ болон сумдын ИТХ-д албан шаардлага хүргүүлээ.


1.16. Хуулийн 12 дугаар зүйлд заасан гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр болон бусад хуулиар санхүүжүүлэх, зарцуулахыг хориглосон заалтыг зөрчсөн зөрчил 2022 онд 14, 2023 онд, 2, 2024 онд 6 гарч нийт 305.8 сая төгрөг зарцуулсан байна.

График 1 Хуулийн 12 дугаар зүйлийг зөрчсөн байгууллага, зөрчлийн тоо, төсөв (сая.төг)

² Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн



Цаашид хуулийг хэрэгжүүлж төсвийн хөрөнгөөр хувцас худалдан авахгүй, хориглосон зардлыг санхүүжүүлэхгүй, хууль зөрчиж зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд томилж, цалинжуулахгүй байх байх шаардлагатай байна.

А.2. Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгал зүйл авах, контент бэлтгэх зөрчил жил бүр давтагдсаар байна.


2.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит газрууд хуулийн 15 дугаар зүйлд заасан хориглолтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

2.2. Аймгийн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн зардлаас үндсэн чиг үүрэг үйл ажиллагаатай холбогдолгүй хандив тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргасан дараах алдаа зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Чинээлэг малчин хөтөлбөрийн зардлаас 46.0 сая төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл худалдан авсан,
- Говь+Ус хөтөлбөрийн зардлаас 30.0 сая төгрөгөөр бөхийн барилдаан зохион байгуулсан,
- Цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийн зардлаас томилолтын зардал олгосон гэх мэт зөрчлүүд илэрсэн.

2.3. Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгал зүйл авах, контент бэлтгэх, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх, дэмжлэг урамшуулал олгох зэрэг хориглосон зөрчлийн тоо өмнөх онуудаас буурсан ч зарцуулсан хөрөнгө өссөн байна.

3. *График 2 Хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн байгууллага, зөрчлийн тоо, төсөв (сая.төг)*



3.1. Байгууллагуудын цахилгаан, дулааны зардал өсөж, цэвэр усны хэрэглээний зардал буурсан байна.

3.2. Цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэглээг хэмнэсэн байдалд нийт 128 байгууллагыг түүвэрлэн авч үзэхэд:

- Цахилгааны зардал 2023 оноос нийт 311.0 сая төгрөгөөр өссөн,



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

- Дулааны зардал 2,639.0 сая төгрөгөөр өссөн,
- Усны хэрэглээ 397.8 сая төгрөгөөр буусан байна.

График 3. Цахилгаан, дулааны зардал өсөж, цэвэр усны хэрэглээний зардлын үзүүлэлт



3.3. Хуулийн 15.2.2³ -т заасан нэгдсэн халаалтын системд холбогдсон байгууллагууд хэмнэлтийн горимд тохируулах, тоолуурыг аймгийн төвд 6 байгууллага ашиглаж байна.

3.4. Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх, нэгдсэн халаалтын системд холбогдсон бүх байгууллага хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1. Хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зохион байгуулах журмыг зөрчсөн зөрчил буурч байна.

1.1. Хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчил 2022 онд 5, 2023 онд 8, 2024 онд 2 гарч нийт 2,083.6 сая төгрөг зарцуулсан байна. Тус зөрчлүүдийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 3: Хуулийн 13 дугаар зүйлд заасан зөрчил заалтаар (сая.төг)

№	Хуулийн заалт	Зөрчлийн тоо			Дүн (сая.төг)		
		2022	2023	2024	2022	2023	2024
1	13.1.2 энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох	0	1	1	-	-	-
2	13.1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;	1	0	0	649.6	-	-
3	13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;	2	2	1	317.7	44.8	16.2
4	13.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;	1	2	0	307.8	144.9	-
5	13.3.1.хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах;	0	1	0	-	8.0	-

³ ТХТХ-ын 15 дугаар зүйлийн 15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

6	13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;	0	2	0	-	217.4	-
7	13.5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.	1	0	0	377.0	-	-
Нийт		5	8	2	1,652.2	415.1	16.2

1.2. Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 1-ны өдрийн 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 214 хөрөнгө оруулалтын, төсөл арга хэмжээг баталсан байна. Хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлахдаа хуульд заасан хориглосон заалтыг зөрчөөгүй байна.

Б.2. Цахим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй зөрчил өссөн байна.

2.1. Өмнөговь аймгийн ХААГ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 504 бараа, ажил, үйлчилгээний жагсаалт болон 15 сумын ЗДТГ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 667 бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан байна.

Хүснэгт 4: Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө

(сая.төг)

№	Байгууллага	Ажил, үйлчилгээний тоо	Төсөвт өртөг
1	Худалдан авах ажиллагааны газар	504	537,524.6
2	Баяндалай сумын ЗДТГ	34	1,252.1
3	Баян-Овоо сумын ЗДТГ	39	3,982.9
4	Булган сумын ЗДТГ	31	9,788.7
5	Гурвантэс сумын ЗДТГ	47	17,885.6
6	Даланзадгад сумын ЗДТГ	71	18,379.5
7	Мандал-Овоо сумын ЗДТГ	13	737.4
8	Манлай сумын ЗДТГ	50	6,678.2
9	Ноён сумын ЗДТГ	30	6,424.5
10	Номгон сумын ЗДТГ	44	6,111.7
11	Сэврэй сумын ЗДТГ	44	10,991.9
12	Ханбогд сумын ЗДТГ	69	79,658.1
13	Ханхонгор сумын ЗДТГ	33	4,581.4
14	Хүрмэн сумын ЗДТГ	29	1,380.8
15	Цогт-Овоо сумын ЗДТГ	26	2,927.5
16	Цогтцэций сумын ЗДТГ	107	19,146.6
НИЙТ		1171	727,451.50

2.2. Хуулийн 14 дүгээр зүйлд заасан бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах, цахим дэлгүүрээс худалдан авалт хийх ажил хангалтгүй байна.

Хүснэгт 5. Хуулийн 14 дүгээр зүйлийн зөрчил заалтаар:

(сая.төг)

№	Хуулийн заалт	Зөрчлийн тоо			Дүн (сая.төг)		
		2022	2023	2024	2022	2023	2024
1	14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт	4	4	3	785.1	59.6	439.5



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

	байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.						
2	14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.	0	0	3	-	-	104.5
3	14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.	1	8	9	-	231.7	24.8
4	14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.	0	1	0	-	-	31.8
Нийт		5	13	15	785.1	323.1	568.8

2.3. Цахим худалдан авалтын талаар авах арга хэмжээг зөрчсөн зөрчил 2022 онд 17, 2023 онд 18, 2024 онд 16 гарч нийт 2,178.3 сая төгрөгийн барааг цахим дэлгүүрээс авалгүй бусад этгээдээс авсан байна.

БҮЛЭГ 3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН ЗӨРЧЛИЙН ТОО БУУРСАН БАЙНА.

В.1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажилласан байна.

1.1. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар тус хуулийн 19 дүгээр зүйлд заасны хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэн санхүүгийн тайлангийн аудитаар 2023-2025 онд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 194 байгууллагын нийт 5,285.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 145.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 8,817.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,952.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 5.0 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба нь 2024 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 36 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 36 байгууллагад дотоод аудит хийсэн байна.

1.3. Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн “Төсвийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгавраар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэх талаар үүрэг даалгаврын төсвийн бүх захирагч нарт өгсөн байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс албан даалгаврын хэрэгжилтийг 98 хувьтай үнэлсэн байна.

В.2 Төрийн хэмнэлтийн хуульд заасан тээврийн хэрэгсэл, албан томилолт, цалин хөлс нэг удаагийн тэтгэмж урамшуулалтай холбоотой зөрчил 2024 онд гараагүй байна.

2.1. Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 19/28 дугаар “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоол болон сумдын тодотгосон төсвийн тогтоолоор аймгийн нийт зарлагыг 2,296,856.3 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,904,419.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 82.9 хувьтай байна.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

Төсвийн гүйцэтгэл 1,904,419.0 сая байгаа нь батлагдсан төсвөөс 392,437.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,904,419.0 сая төгрөг буюу 82.9 хувьтай байгаа нь урсгал зардлыг 249,787,2 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний зардлыг 49,203.0 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 518.6 сая төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

2.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах заалтуудыг баримталж ажиллаагүй 12.3 сая төгрөгийн дараах зөрчлийг 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлэн албан шаардлага өгч, хэрэгжилтийг хангуулсан байна. Үүнд:

- Бараа үйлчилгээний бусад зардлаас тэмцээн уралдааны дэмжлэг, шагналд 5,591,500 төгрөг,
- Хурлын даргын нөөц сангаас Сум дундын 1 дүгээр Прокурорын газарт ойн арга хэмжээний дэмжлэгт 3,000,000,
- Сум дундын шүүхийн ойн арга хэмжээний зардалд 3,000,000 төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст 682,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр төрийн байгууллагууд дараах арга хэмжээнүүдийг авч ажилласнаар хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийг зөрчсөн зөрчил 2024 онд илрээгүй байна. Үүнд:

- Зарим сургалт семинарыг онлайн хэлбэрээр зохион байгуулах,
- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх, зэргээр цаас хорыг хэмнэсэн,
- Суудлын авто машин ашиглах эрхгүй албан тушаалтанд тээврийн хэрэгсэл ашиглуулаагүйгээс шатахууны зардлыг хэмнэж ажилласан,
- Томилолтын зардал олгохдоо байрны зардлыг и баримтгүй бол олгоогүй, зөвхөн хоолны зардлыг олгосон зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

В.3 Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1. Хуулийн 20.1-д хамаарах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 44 газар аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулсан, 4 газар байршуулаагүй байна.

3.2. Хуулийн 20.3-т хамаарах Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй орон нутгийн өмчит 4 хуулийн этгээдийн зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох сонгон шалгаруулалтын зарыг цахим хуудаснаас хайхад “Тавантолгой” ХК болон “Даланзадгадын дулаан хангамжийн газар”-ын сонго шалгаруулалтын зарыг байршуулсан байна.

4. Аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн 2023, 2024 оны аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Тодруулбал:

- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг тус тус мэдээлээгүй байна.
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг үнэн зөв, бүрэн байршуулаагүй



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн мэдээллийг байршуулаагүй байна.
- Дараа жилийн зорилтод түвшин, байгууллагын батлагдсан төсөв, хөрөнгө зарцуулсан шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тус тус мэдээлээгүй гэрэг алдаа зөрчлүүд илэрсэн байна.

4.1. Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн зөрчсөн 2022 онд 2, 2024 онд 14 зөрчил илрүүлж албан шаардлага, зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан байна.

4.2. Цаашид шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, бүрэн мэдээлж байх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон албан хаагчдын цалингийн жишгийг батлаагүй байна.
- Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгал зүйл авах, контент бэлтгэх зөрчил жил бүр давтагдсаар байна.
- Хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зохион байгуулах журмыг зөрчсөн зөрчил буурч байна.
- Цахим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй зөрчил өссөн байна.
- Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд арга хэмжээ авч ажилласан байна.
- Төрийн хэмнэлтийн хуульд заасан тээврийн хэрэгсэл, албан томилолт, цалин хөлс нэг удаагийн тэтгэмж урамшуулалтай холбоотой зөрчил 2024 онд гараагүй байна.
- Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/09

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэхийг аудитын багийн ахлагч аудитор (М.Номиндарь)-д үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (М.Номиндарь)-т даалгасугай.



ЦӨСӨХБАЯР

4625010034

